Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДЛОГЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ С.ЭРДЭНЭТУЯАГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Зорилт 1. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд 2024 оны жилийн эцэс, 2025 оны сар бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | ХШҮ-ний тайлан | Жилийн эцсээр болон сар бүр үнэлгээ хийж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын цахим мэдээллийн санд оруулдаг. | 2024 оны жилийн эцсийн болон 2025 оны 1-5 дугаар сарын хэрэгжилтийн үнэлгээ хийж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын цахим мэдээллийн санд оруулсан байна. | 2024 оны жилийн эцэст 202 шийдвэрийн 423 зүйл, заалт (МУ-ын хуулийн зүйл, заалт 56, УИХ-ын тогтоол 64, УИХ-ын Байнгын хорооны тогтоол 56, Ерөнхийлөгчийн зарлиг 7, ЗГ-ын тогтоол 69, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл 140, ЗГ-ын албан даалгавар 16, ҮАБЗ-ийн зөвлөмж 15)-аар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд холбогдох журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд оруулж, ЗГХХГ-т хууль тогтоомжийн заалтуудаас “бүрэн хэрэгжсэн”, “хамааралгүй” 67 заалтыг хасуулах саналын 2025 оны 2/153 албан тоотоор хүргүүлсэн. | 2025 он 1-5 дугаар сар | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | 2025 оны 1 дүгээр сарын байдлаар Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгавраар Эрүүл мэндийн сайд, Эрүүл мэндийн яаманд үүрэг болгосон 133 шийдвэрийн 235 зүйл, заалтын хэрэгжилтэд холбогдох журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын цахим системд оруулсан.<br><br>2025 оны 3 дугаар сарын байдлаар Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгавраар Эрүүл мэндийн сайд, Эрүүл мэндийн яаманд үүрэг болгосон 127 шийдвэрийн 196 зүйл, заалтын хэрэгжилтэд холбогдох журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын цахим системд оруулсан.<br><br>ЗГХЭГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайдаас эрүүл мэндийн чиглэлээр өгсөн шуурхай үүрэг даалгаврын биелэлтээс хангалтгүй, хэрэгжээгүй, удааширсан 17 шийдвэрийн 22 үүрэг даалгаврын хэрэгжилтэд 2025 оны 5 дугаар сарын байдлаар хяналт- | | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | шинжилгээ, үнэлгээ хийж дүн, тайланг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд оруулж, ЗГХЭГ-т 2025 оны 2/2565 албан тоотоор хүргүүлсэн.<br><br>Хууль, тогтоомжийн заалтуудаас “хэрэгжилт хангалтгүй”, “хэрэгжээгүй”, цаашид эрчимжүүлэх шаардлагатай байгаа заалтуудын хэрэгжилтийг сайжруулах талаарх ТНБД-ын “Дотоод меморандум”-ыг 2025 оны 1 сарын 9, 2 сарын 19, 4 сарын 17-ны өдөр яамны холбогдох газруудад тус тус хүргүүлсэн. | | |
| 2 | Арга хэмжээ 1.2 Засгийн газрын тогтоолоор баталсан хэм хэмжээний актад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж | ХШҮ-ний тайлан | ХШҮ-ний тайлан | Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан хэм хэмжээний актад хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан Засгийн газрын шийдвэрээр батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг хүлээсэн 15 хуулийн 27 заалтыг дагаж гарсан тогтоол, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг ЗГХЭГ, ХЗДХЯ-нд 2025 оны 2/3035 албан бичгээр хүргүүлсэн. | 2025 он 4-6 дугаар сар | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Зорилт 2. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 2.1. ЭМБ-уудын 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | ХШҮ-ний тайлан | Жил бүр үнэлгээ хийж, Удирдлагын зөвлөлд танилцуулдаг | Удирдлагын зөвлөлд танилцуулсан байна. | Эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээнд ЭЭХХЗГ, ЭМДЕГ, УХТЭ, СЭМҮТ, АӨСҮТ, НЭМҮТ, ХӨСҮТ, ХСҮТ, ГҮТ, ЦССҮТ, ЭМХТ, НЭМГ, Баян-Өлгий, Дархан-Уул, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газар, Өмнөговь, Ховд аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв зэрэг 25 эрүүл мэндийн байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээг хийж, тайланг боловсруулсан.<br>Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2024 оны гүйцэтгэлийн үнэлгээний дүн, санал, зөвлөмжийг 8/2075-2096, яамны харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны гүйцэтгэлийн үнэлгээний дүнг 8/2306-2329 дугээр албан бичгээр байгууллага тус бүрт хүргүүлсэн. | 2025 он 1-3 дугаар сар | |
| 2 | Арга хэмжээ 2.2. Төлөвлөгөөт бус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | ХШҮ-ний тайлан | ЕТГ, УИХТГ, ЗГХЭГ, ЗГХХГ зэрэг дээд шатлалын байгууллагуудаас өгсөн чиглэлийн дагуу тухай бүр | Холбогдох байгууллагад тайланг хүргүүлсэн байна. | ЕТГ-ын даргын шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсгээс өгсөн үүргийн дагуу УИХ-ын "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 2022 оны 36 дугаар тогтоолоор ЭМЯ хариуцах арга хэмжээний хэрэгжилтэд 2025 оны 3 дугаар сар болон 5 | 2025 он 3-5 дугаар сар | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | хийж тайланг хүргүүлдэг. | | дугаар сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүн тайланг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд оруулсан. ЗГХХГ-аас дээрх тогтоолын хэрэгжилтийн үнэлгээнд шаардлагатай байгаа нэмэлт мэдээллийг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.<br><br>Уг тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх болох "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай", "Хүнсний тухай" хуулиудад заасан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлах дүрэм, журмыг яаралтай шинээр болон шинэчлэн боловсруулж батлуулах, эдгээр хуулиудад эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцахаар заасан чиг үүргүүдийг хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар ТНБД-ын "Дотоод меморандум"-ыг 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр НЭМБГ-т хүргүүлсэн. | | |

## Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. | Арга хэмжээ 1.<br><br>Мэдээллийн аюулгүй байдлын сургалтад хамрагдах | Гэрчилгээ | - | Сургалтад хамрагдсан байна. | ЗГХЭГ, Удирдлагын академи, Infosolution ХХК хамтран зохион байгуулдаг "Microsoft 365 программын хэрэглээ" сэдэвт цахим сургалтад 2025 оны 3 дугаар сард хамрагдсан. | 2025. 03.17-03.19 | |
| 2. | Арга хэмжээ 2.<br><br>Хяналт-шинжилгээ, үнэлгээний сургалтад хамрагдах | Гэрчилгээ | - | Сургалтад хамрагдсан байна. | "Монгол Улсын хөгжлийн бодлогын үнэлгээний чадавхын индекс тогтоох", "Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх арга зүй" сургалтад 2025.05.14, 05.16-ны өдөр оролцож, гэрчилгээ (№20250164) авсан. | 2025.05.14-05.16 | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

| | | |
|---|---|---|
| Ахлах шинжээч | С.Эрдэнэтуяа / ........................ / | 2025.06.09 |
| *(Албан тушаал)* | *(Нэр, гарын үсэг)* | *(Огноо)* |